



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 19 өдөр

Дугаар A/86

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 416 дугаар тушаалын Эрдэнэбаяр овогтой Содбилэг, Батсайхан овогтой Танхилсайхан, Наран овогтой Тунгалаг, Бат-Эрдэнэ овогтой Батбилэг нартай холбогдох хэсгийн “1,5 жилийн хугацаатайгаар” гэснийг “2 жилийн хугацаатайгаар” гэж, 2012 оны 1 дугаар сарын 12-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тушаалын Цэвээнравдан овогтой Оюунзаяатай холбогдох хэсгийн “АНУ-ын Нортвестрн Политехникийн их сургуулийн магистрантурт” гэснийг “Малайз Улсын Ази, Номхон далайн технологи, инновацийн их сургуулийн магистрантурт” гэж, 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” A/381 дүгээр тушаалын Даваадорж овогтой Очирпүрэвтэй холбогдох хэсгийн “АНУ-ын Виржинийн их сургуулийн” гэснийг “Австрали Улсын Сиднейн Технологийн их сургуулийн” гэж, 2010 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 591 дүгээр тушаалын Баясгалан овогтой Мөнхтүлгатай холбогдох хэсгийн “2 жилийн хугацаатайгаар” гэснийг “2,5 жилийн хугацаатайгаар” гэж, 2011 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 276 дугаар тушаалын Сэвжид овогтой Дэжидноровтой холбогдох хэсгийн “Австрали Улсын Нью Саут Уельсийн их сургуулийн” гэснийг “БНСУ-ын Вонгуан их сургуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР